

**“СТАНДАРТ НООС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024.03.22.

Улаанбаатар хот

Дугаар № 01/ 2024










Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг
томилох тухай

“Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаас сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн анхдугаар хуралдааны хэлэлцсэн асуудлын дагуух санал хураалтын дүн болон Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78.1. дүгээр заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ :**

1. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Цоодолын Зоригтыг томилсугай.
2. Компанийн тухай хууль болон Компанийн дүрмэнд тусгагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүргийг ёсчлон биелүүлж, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүтээлчээр удирдан хянаж ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргад зөвлөсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ГИШҮҮД :

	Б.БАТБОЛД
	Б.БАЯСГАЛАН
	З.МӨНХМАА
	Ц.ЗОРИГТ
	Л.ЦЭВЭЭНРАВДАН
	Л.ЦЭНДЭЭХҮҮ
	Б.УРАНБИЛЭГ
	Ё.ЭНХТӨР
	З.ЭРДЭНЭЭ

**“СТАНДАРТ НООС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024.03.22.

Улаанбаатар хот

Дугаар № 02/ 2024

Хороодын гишүүдийг батлах тухай

“Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн анхдугаар хуралдааны хэлэлцсэн асуудлын дагуух санал, шүүмжлэл, санал хураалтын дүн болон Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81.2., 81.4.–81.6. дугаар зүйлүүдийг үндэслэн **ТОГТООХ НЬ :**

1. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд :
Хорооны дарга Б.Баясгалан
Гишүүд : З.Мөнхмаа
 Б.Уранбилэг
2. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд :
Хорооны дарга Л.Цэвээнравдан
Гишүүд : З.Эрдэнээ
 Б.Уранбилэг
3. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд :
Хорооны дарга Б.Уранбилэг
Гишүүд : Б.Баясгалан
 Л.Цэндээхүү
4. Компанийн тухай хууль болон Компанийн дүрмэнд тусгагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодуудын эрх, үүргийг ёсчлон биелүүлж, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүтээлчээр оролцож, компанийн гүйцэтгэх удирдлагыг дэмжин туслаж ажиллахыг хорооны нийт гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Ц.ЗОРИГТ



**“СТАНДАРТ НООС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024.03.22.

Улаанбаатар хот

Дугаар № 03/ 2024

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн
бичгийн даргыг томилох тухай

“Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн анхдугаар хуралдааны хэлэлцсэн асуудлын дагуух санал, шүүмжлэл, санал хураалтын дүн болон Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийг үндэслэн **ТОГТООХ НЬ** :

1. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Л.Цэвээнравданг томилсугай.
2. Компанийн тухай хууль болон Компанийн дүрмэнд тусгагдсаны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, ТУЗ-ийн бичиг баримт, албан хэргийг зохих ёсоор хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.ЗОРИГТ